



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/118

Төмөрбулаг сум

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг
хязгаарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.1, Аймгийн Засаг даргын 2023 оны А/148 дугаар захирамжийн 2,3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Мал амьтны гоц халдварт өвчин зөөвөрлөгдөн дамжин тархах болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гоц халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн бүс нутгаас шилжилт хөдөлгөөнийг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хязгаарласугай.
2. Мал амьтны өвчлөлийн дуудлага, эрүүл мэндийн үзлэгт онцгой анхаарч ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.
3. Мал амьтны гоц халварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт, тархвар зүйн судалгаа хийж, мал амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг чангатган, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн (Э.Мөнгөнзагас)-т, малчид, мал бүхий иргэд, бизнес эрхлэгч нарт мэдээлэл түгээж, орон нутгийн түвшинд хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг багийн засаг дарга нарт даалгасугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Тамгын газрын дарга (Г.Нямханд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.БЯМБАСҮРЭН